

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН УЛААНХУС СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧИЙН АЖЛЫН БАЙРАНД БОЛОН МОНГОЛ-АЛТАЙН НУРНУУЫ УТХГ-ЫН ХАМГААЛАЛТЫН
ЗАХИРГААНЫ АЛТАЙ СУМЫН ЁЛТЫН САВ ГАЗРЫГ ХАРИУЦСАН БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧИЙН АЖЛЫН БАЙРЫГ НӨХӨХ
СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ ЗАРЛАЖ БАЙНА**

Өлгий хот

2016.03.07

Нэг.Нийтлэг зүйл

1. Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5-д “Хуульд өөрөөр заагаагүй бол ажил олгогч төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тооны талаар нийтэд мэдээлэх үүрэгтэй” гэсний дагуу Улаанхус сумын ЗДТГазраас болон Монгол Алтайн нурууны УТХГ-ын Хамгаалалтын захиргаанаас ирүүлсэн сул орон тоог нийтэд зарлаж байна.
2. Зарлагдаж буй сул орон тоонд Төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчид болон төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэлтэй, тухайн албан тушаалд тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадвар болон тусгай шаардлагыг хангасан, энэ албан тушаалд ажиллахыг хүссэн Монгол Улсын иргэн санал хүсэлтээ гаргаж болно. Тус аймгийн нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйл, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-ын дагуу нөхөх үйл ажиллагааг зохион байгуулна. Аймаг дахь төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл зарын дагуу бүртгүүлсэн нөөцөд байгаа иргэнийг тухайн ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлагыг хангаж байна гэж үзсэн тохиолдолд мэргэшлийн шалгалт өгсөн төрийн жинхэнэ албан тушаалын ангилал дотор төрийн жинхэнэ албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж болно.

3. Сонгон шалгаруулалтын зорилго

Төрийн албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан, төрийн албаны зорилт, чиг үүргийг мэргэшлийн өндөр түвшинд хэрэгжүүлэх удирдах ажилтныг болон гүйцэтгэх ажилтныг шилж сонгоход оршино.

- Сонгон шалгаруулалтад орох иргэд нь Төрийн албаны тухай хуулийн 10.1 -д заасан ерөнхий шаардлага болон томилох эрх бүхий этгээдийн баталсан тухайн албан тушаал (ажлын байрны тодорхойлолтод заасан)-ын тавигдах дараах шаардлагыг хангасан байна.

1. БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН УЛААНХУС СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧИЙН АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Ерөнхий шаардлага	Үзүүлэлт	Чухал шаардлагатай	Шаардлагатай
	Боловсрол	Бакалавр	Магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх
	Мэргэжил	Нягтлан бодох бүртгэл, санхүү, эдийн засаг	Мэргэшсэн нягтлан бодогчийн зэрэгтэй байх нь давуу тал болно
	Туршлага	Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, үүнээс төвлөрүүлэн захирагчийн нягтлан бодогчоор 3-аас доошгүй жил ажилласан байх	-
	Ур чадвар	<ul style="list-style-type: none"> · Хэл бичгийн дүрэм, найруулга зүй, албан хэрэг хөтлөлтийн стандартын мэдлэг, ур чадвартай байх, · Удирдан зохион байгуулах чадвартай, · Компьютерийн өргөн хэрэглээний програмд ажиллах чадвартай байх 	Багаар ажиллах, хамт олныг удирдан чиглүүлэх, өөрчлөлтийг манлайлах, үр дүнд чиглэн ажиллах, мэдээллийн технологи, сүлжээний үйл ажиллагааг удирдах, НҮБ-ын албан ёсны аль нэг хэлний зохих мэдлэгтэй байх
Тусгай шаардлага		<p>Хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөргүй, Захиргааны хариуцлагын тухай хуулийн 36,43.1,43.2 дугаар зүйлийн дагуу захиргааны болон бусад шийтгэлгүй байх,</p> <p>Албан тушаалтан нь хууль дээдлэх зарчимд захирагдан, албан үүргээ иргэдийн итгэл хүлээхүйц, тэгш, шударга, хариуцлагатайгаар гүйцэтгэж, албаны ёс зүйг сахина,</p> <p>Ашиг сонирхлын зөрчилд орж болох нөхцөл байдлыг мэдэгдэх, түүнээс татгалзах замаар урьдчилан сэргийлнэ</p>	Төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг хэлбэрэлтгүй сахих, ашиг сонирхлын зөрчилгүй байх, төрийн болон байгууллага, хувь хүний нууцыг хадгалах

2. Монгол-Алтайн нурууны Улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргааны Ёлтын сав газрыг хариуцсан байгаль хамгаалагчийн ажлын байранд тавигдах шаардлага

Байршил	Захиалга өгсөн байгууллага	Нэгжийн нэр	Албан тушаалын			Ажлын байранд тавигдах шаардлага				
			Ангилал	Нэр	Хариуцсан асуудал	Боловсрол	Мэргэжил	Туршлага	Ур чадвар	Тусгай шаардлага
Баян-Өлгий аймаг	Монгол Алтайн нурууны УТХГазрын Хамгаалалтын захиргаа	Хамгаалалтын захиргаа	Туслах түшмэл ТЗ-2	Байгаль хамгаалагч	Алтай сумын Ёлтын сав газрыг хариуцсан	Бакалавр	Экологч, байгааль хамгаалал, эрх зүйч	Харгалзахгүй	Багаар ажиллах чадвартай, баримт бичиг боловсруулах, зөрчлийн хянан шийдвэрлэх, компьютерийн мэдлэгтэй байх	Хариуцан хамгаалж буй нутаг дэвсгэрт амьдарч, ажиллах, сэлгэн ажиллах, хууль дээдлэх, үнэнч шударга байх, ТАХ-ийн ёс зүйн хэм хэмжээг сахих

БҮРТГЭЛИЙН ХУГАЦАА Зарлагдсан төрийн жинхэнэ албан тушаалын ажлын байрны сул орон тоонд ажиллахыг хүссэн иргэд тус аймгийн Засаг даргын Тамгын газар дээр 2016 оны 03 дугаар сарын 16,17-ны өдрүүдэд 10.00-17.00 цагийн хооронд өөрийн биеэр ирж бүртгүүлнэ.

Иргэд бүртгүүлэхдээ өөрийн боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадвар, тусгай шаардлагын талаар дэлгэрэнгүй мэдээллийг үнэн зөв, товчилсон нэр, томъёо хэрэглэхгүй мэдээлэх шаардлагатай. Мөн холбоо барих утасны дугаар, гэрийн хаяг, e-мэйл хаяг зэргийг тодорхой дурдана.

Гурав. БҮРТГҮҮЛЭХ ИРГЭДЭД ТАВИХ ШААРДЛАГА

1. Бүртгүүлэгч хуурамч баримт материал бүрдүүлэхгүй, худал мэдүүлэхгүй байх үүрэг хүлээнэ.

Бүртгүүлэх иргэн дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ. .

Тухайн албан тушаалд ажиллахыг хүссэн өргөдөл /Иргэн ажилд орохыг хүссэн өргөдөлдөө төрийн албаны мэргэшлийн шалгалтыг хэдэн оны хэдэн сард хаана, ямар байгууллага, ажлын байранд өгч тэнцсэн тухай дэлгэрэнгүй мэдээллийг бичнэ/

Төрийн албан хаагчийн анкет /Төрийн албан хаагчийн анкетыг маягт N1-ийн дагуу бүрэн бөглөсөн байх/ .

Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/-ийн эхийг нотариатаар гэрчлүүлсэн хуулбарын хамт .

Иргэний үнэмлэхний эх, хуулбарын хамт .

“4x6”-гийн хэмжээний цээж зураг 4 хувь .

Ажилласан хугацаа болон ажил эрхлэлтийг гэрчлэх баримт /Нийгмийн даатгал, хөдөлмөрийн дэвтэр/-ын эх хувь